

*Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2009 онд
нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний
дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан*



Улс, орон нутгийн төсөв, МУХС, гадаадын зээл, тусламжийн
хөрөнгөөр 2008 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын
хэрэгжилт, үр дүн

Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбар

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГА, САНХҮҮЖИЛТИЙН
ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БУС БАЙНА**

Агүүлга

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт	3
ҮАГ-ын Нэгдүгээр газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
Газрын захирал Ц.Батбаяр	Бүлэг 1: Дунд хугацааны хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт үгүйлэгдэж байна	5
Аудитын менежер Ж.Батсайхан	1.1 Зураг, төсөвгүй төсөл арга хэмжээг төсөвт тусгасан байна	5
Ахлах аудитор Ц.Гэрэл	1.2.Хөрөнгө оруулалтын талаар баримтлах бодлого төлөвлөлт дутагдаж байна	5
Аудитор Д.Уртнасан	1.3. Барилга объектын анхны төсөвт өртгийг нэмэгдүүлсэн ч объект нь ашиглалтад ороогүй байна	6
Шинжээч Б.Болормаа	Бүлэг 2: Худалдан авах ажиллагааны гүйцэтгэгч сонгох аргыг буруу хэрэглэсэн байна	
Шинжээч Ц.Эрдэнэчулуун	2.1.Худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод байх зарчим алдагдсан байна	9
	2.2. ХАА-ны гүйцэтгэгч сонгох аргыг буруу хэрэглэсэн байна	10
	2.3. ХАА-г хуулийн хугацаанд тайлагнах явдал хангалтгүй байна	10
	Бүлэг 3: Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай байна	
	3.1.Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай байна	12
	3.2.Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх, түүний үр дүнг үнэлэх, хариуцлага тооцох тогтолцоо байхгүйгээс гэрээний хэрэгжилт хангалтгүй байна	13
Уг тайланг ҮАГ-ын веб сайтаас үзнэ үү: www.mnao.pmis.gov.mn	3.3.Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй байна	15
	Бүлэг 4: Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн тогтолцоо оновчгүй байна	
	4.1.Санхүүжилт олгож буй өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна	16
	4.2.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж буй ажилтнуудын хоорондын ажлын уялдаа холбоо оновчтой биш байна	18
	4.3.Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үе шатны ажилд үр нөлөөтэй байнгын хяналт тавиагүй байна	19
	Дүгнэлт	20
	Зөвлөмж	21
ХАЯГ: Үндэсний аудитын газар Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс	Холбогдох байгууллагын санал Саналд өгсөн тайлбар Хавсралтууд: Хавсралт 1 Хавсралт 2 Хавсралт 3 Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал	22

Товчилсон үгийн жагсаалт

АӨСТ	Арьсны өвчин судлалын төв
БЗА	Барилга захиалагчийн алба
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МӨСҮТ	Мэргэжлийн өвчин судлалын үндэсний төв
МУ	Монгол Улс
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
СЯ	Сангийн яам
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТББ	Тендерийн баримт бичиг
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
УИХ	Улсын Их Хурал
УНДЕГ	Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААБЗГ	Худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалтын газар
ХНМӨСҮТ	Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн өвчин судлалын үндэсний төв
ХХҮХ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс
ХХХСҮ	Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэр
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудитор Ундэсний аудитын газраас 2009 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Ундэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Улс, орон нутгийн төсөв, МУХС, гадаадын зээл, тусламж, өөрийн хөрөнгө, урсгал зардал, бусад эх үүсвэрээр 2008 онд Эрүүл мэнд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг шалгаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Энэ зорилтын хүрээнд дараахь чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт, түүний үндэслэл, үр нөлөө
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох ажиллагаа, түүний зохион байгуулалт, үр нөлөө
- Захиалагчийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний гүйцэтгэлийг үнэлэх, хариуцлага тооцох үйл явцын хэрэгжилт, түүний үр нөлөө
- Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, хяналтын үйл ажиллагааны удирдлага, санхүүжилтийн тогтолцоо оновчтой, үр ашигтай, үр нөлөөтэй зохион байгуулагдсан эсэх

Хамарсан хүрээ

Аудитад ЭМЯ, НХХЯ, УНДЕГ, тэдгээрийн харъяа агентлаг, төв, орон нутгийн ХХҮХ, эмнэлгүүд хамрагдлаа.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитын дараахь арга зүйг ашиглав. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын бодлого, төсвийн хүрээний мэдэгдэл, төлөвлөлтийн тооцооллын талаар аудитад хамрагдсан байгууллагуудын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тэднээс лавлагаа, тодруулга авах;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгосон ажиллагааны талаархи материалыг аудитад хамрагдсан байгууллага бүрээр түүвэрлэн авч танилцах;
- Захиалагчийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний гүйцэтгэлийг аудитад хамрагдсан байгууллагаас түүвэрлэн авч биет байдалтай нь тулган баталгаажуулах, гэрээг хугацаанд нь биелүүлээгүй шалтгаан, хариуцлага тооцсон эсэхийг захиалагч, гүйцэтгэгч нараас асууж тодруулах;
- СЯ, захиалагчаас гүйцэтгэгчид санхүүжүүлсэн дүнг төсөл, арга хэмжээ бүрээр гэрээний дүн болон хөрөнгө оруулалтын тайлантай тулган баталгаажуулах

Аудитын явцад шалгах хуудсыг ашигласан ба аудит эхлэхээс өмнө ЭМЯ, НХХЯ, тэдгээрийн харъяа байгууллагуудаас хөрөнгө оруулалтын талаар гаргуулан авсан судалгааг тулган баталгаажуулав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1

Дунд хугацааны хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт үгүйлэгдэж байна

2008 онд эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт улсын төсвөөс 23.1 тэрбум төгрөг, Монгол Улсыг хөгжүүлэх сангаас 8.9 тэрбум төгрөг, нийт 32.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр баталсан байна. Үүнээс барилга байгууламж барихад 15.6 тэрбум, их засварт 5.8 тэрбум, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил авахад 10.1 тэрбум төгрөг тус тус төлөвлөжээ.

1.1 ЭМ-ийн салбар зураг, төсөвгүй төсөл арга хэмжээг төсөвт тусгасан байна

Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмын 2.2-т "Тухайн санхүүгийн жилд шинээр эхлэхээр тооцож буй төсөл, арга хэмжээ, барилга байгууламж нь ...хайгуул, зураг төслийн ажил нь хийгдсэн, инженерийн сүлжээний хангамжийн асуудал шийдэгдсэн, үр ашигтай нь техник эдийн засгийн тооцоогоор нотлогдсон зэрэг барилгын ажил эхлэх нөхцлийг хангасан байна" гэснийг зөрчиж, барилга барих газрын зөвшөөрөл гараагүй, зураг төсөв батлагдаагүй барилга объектыг төсөвт тусгаснаас түүний хэрэгжилт удааширч байна.

ЭМ-ийн салбарт 2008 онд 9.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 объектыг нийслэлд барихаар 5.5 тэрбум төгрөг баталсан боловч зураг төсөвгүй, барилга барих газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл аваагүйн улмаас 5.2 тэрбум төгрөг төсвийн тодотголоор хасагдаж, зөвхөн нэг объектын гүйцэтгэгчтэй гэрээ хийсэн байна.

- 2008 оны Улсын төсвийн тухай хуульд 650.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр баталсан Ховд аймгийн төрөхийн эмнэлгийн барилгын төсөвт өртгийг 938.0 сая төгрөг болгон нэмэгдүүлж "Ховдын Өргөө" ХХК-тай гэрээ хийсэн ч зураг төсөв бэлэн болоогүй, барилга барих газар чөлөөлөөгүй шалтгаанаар өнөөг хүртэл барилгын ажил эхлээгүй байна.
- Булган аймгийн Хишиг-Өндөр сумын 10 ортой эмнэлгийн барилга гэрээний дагуу 2009 оны 10 дугаар сард ашиглалтад орох байсан боловч ЭМЯ-нд иргэдээс 20 ортой болгохыг хүссэний дагуу барилгын ажлыг зогсоож, зураг төсөвт өөрчлөлт оруулах ажил хийгдэж, барилгын ажил эхлээгүй байна.

1.2. Хөрөнгө оруулалтын талаар баримтлах бодлого, төлөвлөлт дутагдаж байна

Эрүүл мэнд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбар хөрөнгө оруулалтын талаар баримтлах дунд хугацааны бодлого, төлөвлөлт боловсруулж батлаагүй байна. Жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагддаг ирэх 3 жилийн хөрөнгө оруулалтын талаархи төсөөллийн дагуу төсөл арга хэмжээг улсын төсөвт тусгаж иржээ.



1.3. ЭМ-ийн салбар барилга объектын анхны төсөвт өртгийг нэмэгдүүлсэн ч объект нь ашиглалтад ороогүй байна

Зарим барилга, объектын төсөвт өртгийг үнэ ханшийн өөрчлөлтөөс шалтгаалж нэмэгдүүлсэн байна.

- Увс аймагт баригдаж буй спорт цогцолборын төсөвт өртөг анх 2005 оны 12 дугаар сард хийсэн гэрээгээр 975.0 сая төгрөгөөр батлагдсныг 2007 оны 9 дүгээр сард 1225.0 сая төгрөг, улмаар 2008 оны 11 дүгээр сард 1446.0 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн;
- 2007 оноос шилжиж ирсэн Хөвсгөл аймгийн Жаргалант, Сэлэнгэ аймгийн Бугант, Баянхонгор аймгийн Баацагаан сумдын 10 ортой эмнэлэг зэрэг 12 объектод нэмж шаардагдсан 21.0-110.0 сая төгрөгийн санхүүжилтийг “МУ-ын 2008 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулиар тус тус нэмж баталжээ.
- Завхан аймгийн Идэр суманд “Алс” ХХК-ийн барьж буй 10 ортой эмнэлэгт ЭМСХ-2 төслөөс 114.6 сая, улсын төсвөөс 50.0 сая төгрөгийн санхүүжилт олгосноор хоёрдугаар давхарын өрлөг талдаа орсон ч нэмж 67.5 сая төгрөг, Булган аймгийн Хялганат тосгоны Ахмадын сувиллын барилгын төсөвт өртөг 40.9 сая төгрөг батлагдсаны 90 хувийг гүйцэтгэгчид олгосон боловч нэмж санхүүжилт шаардлагатай гэх шалтгаанаар барилгын ажил зогсчээ.

НХХ-ийн салбар төсвийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан байна

НДҮЗ Нийгмийн даатгалын сангийн 2008 оны төсвийн тухай хуулийг зөрчиж 2008 оны 3 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын зарим зардлын зүйл анги хооронд шилжүүлсэн бөгөөд 2008 оны 9 дүгээр сарын 15 дугаар тогтоолоор дээрх хуульд нийцүүлэн залруулжээ. Үүнд:

Албан конторын барилга барих зардлыг 65,0 сая, автомашин худалдан авалтыг 62,0 сая төгрөгөөр хорогдуулж, барилгын их засварыг 11,5 сая, тавилга эд хогшил худалдан авах зардлыг 27,0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Энэ нь барилга барих төсвийг Баянгол дүүргийн НДХ-т 300.0 сая, Завхан аймгийн НДХ-т 65.0 сая, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын НД-ын тасагт 30.0 сая, Сэлэнгэ аймгийн НДХ-т 8.0 сая, автомашин худалдан авах зардлыг Өвөрхангай аймгийн НДХ-т 4.0 сая, Завхан аймгийн НДХ-т 15.0 сая, УНДЕГ-т 28.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

ЭМ, НХХ-ийн салбарт 2008 оны Төсвийн тухай хуульд тусгагдаагүй төсөл, арга хэмжээг нэмж оруулсан, санхүүжилтийн эх үүсвэрийг өөрчилсөн, их засварын зардлыг хөрөнгө оруулалтын зардалд шилжүүлсэн 676,2 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

- Орхон аймгийн Ахмадын сувиллын барилгын ажилд нийт 349,9 сая төгрөгийн гэрээ байгуулсан ба улсын төсвөөс 250.0 сая төгрөг батлагдсан. Төсөвт өртгийн зөрүү 99.9 сая төгрөгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй байхад тендер зарлан, гүйцэтгэгчид санхүүжилтийн 75%-ийг олгож, үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй гэх шалтгаанаар барилгын ажил зогсчээ.
- НХХЯ-ны харъяа ХНМӨСҮТ-өө 2008 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй барилгын зургийн урьдчилгаа, эм урвалж зэрэгт 19.7 сая, “Агаар сувилал”-ын барилгын өргөтгөлийн ажилд 6.2 сая төгрөг тус тус зарцуулжээ.



Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмын 1.5-д “Улсын болон орон нутгийн төсөв, Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг хооронд нь шилжүүлэн санхүүжүүлэхийг хориглоно” гэж заасныг зөрчиж

НХХ-ийн сайдын 2008 оны 05 дугаар тушаалаар хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд дараахь өөрчлөлтүүдийг хийжээ. Тухайлбал,

- Ховд аймгийн Ахмадын байрыг засварлахад 120.0 сая төгрөг батлагдсаныг Ахмадын өргөөний барилга шинээр барих болгон өөрчилж “Ховд Юхо” ХХК-тай 299.9 сая төгрөгийн гэрээ байгуулж, зөрүү 179.9 сая төгрөгийг 2009 оны Төсвийн тухай хуульд тусгуулжээ.
- Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт үйлдвэрийн барилгын их засварт батлагдсан 265.0 сая төгрөгөөс их засварын ажилд 115.0 сая төгрөгийг зарцуулж, үлдсэн 148.2 сая төгрөгийн санхүүжилтийн зориулалтыг өөрчлөн Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт үйлдвэрийн барилгын өргөтгөлд зарцуулжээ. Уг ажилд нэмж 36.1 сая төгрөгийг 2009 оны Төсвийн тухайн хуульд оруулж батлуулжээ.
- СХД-ийн ХХҮХ-ийн барилгын засвар, тохижилтод 180.0 сая төгрөг батлагдсан боловч ННХЯ “Материал трейд” ХХК-тай 268.2 сая төгрөгийн гэрээ хийж гүйцэтгүүлжээ.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн НДХ-ийн хоёр давхар конторын барилгын төсөв 200.0 сая төгрөг батлагдсан боловч анхны зураг төсвийг өөрчлөн гурван давхар болгожээ. Нэмж шаардагдах хөрөнгийн эх үүсвэрт УНДЕГ-аас 77.7 сая, ХААН банкнаас 80.0 сая төгрөг, бүгд 157.7 сая төгрөгийг зарцуулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилгад хувийн өмчийн оролцоо бий болгосон байна.

ЭМЯ, НХХЯ, тэдгээрийн харъяа байгууллагаас хөрөнгө оруулалтын эрэлт, хэрэгцээ, шаардлагыг бодитой тогтоосон эсэх талаар асуулга авав. Нийт 73 асуулгын дүнг нэгтгэхэд 68.5 хувь нь сөрөг, 31.5 хувь нь эерэг хариулт өгчээ.

Сөрөг хариултын дийлэнхийн үндэслэлийг жагсаавал:


- Төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв, мэргэжлийн байгууллагын дүгнэлт зэргийг баримтжуулж баталгаажуулаагүй, зураг төсөв нь бэлэн бус, хэрэгцээ хангаагүй төсөл арга хэмжээнд хөрөнгө зарцуулахаар төлөвлөсөн
- Тухайн жил шинээр эхлэхээр төлөвлөсөн барилга, байгууламж, төсөл арга хэмжээний талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй
- УИХ-ын гишүүд хөрөнгө оруулалтын бодлого төлөвлөлтийг алдагдуулах үйл ажиллагаа явуулсан
- Төлөвлөсөн арга хэмжээ, зураг төсвийн өртгийг үндэслэл муутай тооцсоноос гүйцэтгэлийн явцад нэмэгдэл хөрөнгө шаардагдаж, төсөвт хүндрэл учруулсан
- Захиалагч яам, газар хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө өгөгдсөн санхүүгийн эх үүсвэрийн хэмжээнээс хэтрүүлсэн
- Салбарын яам, газар тухайн салбарын болон бүс нутгийн хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө боловсруулаагүй
- Салбар, орон нутгийн хөгжлийг тусгасан хөрөнгө оруулалтын стратеги төлөвлөгөө байхгүй
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зохицуулалт хийхдээ хууль бус үйл ажиллагаа явуулсан
- Батлагдсан хөрөнгө оруулалтын төсвийг нэмэгдүүлэх, зориулалтыг өөрчилж төлөвлөгөөнд тусгаадаагүй төслийг хэрэгжүүлсэн

Эерэг хариултын олонхийн үндэслэлийг жагсаавал:

- ТЭЗ төсвийн хүрээний мэдээгдлийн дагуу төсвийн төслийг боловсруулсан
- Төсөвт өртгийг байгууллагын удирдлагаар хэлэлцэж батласан
- Сангийн яам хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах, нэгтгэхдээ төрөөс баримталж байгаа Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хэтийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулсан
- ТЭЗ төсвийн хүрээний мэдээгдлийн дагуу төсвийн төслийг боловсруулсан
- Төсвийн төслийг хуулийн хугацаанд Засгийн газар, УИХ-д өргөн мэдүүлсэн
- ТЭЗ-дын боловсруулсан хөрөнгө оруулалтын төсвийн төслийн дийлэнх хувь нь Төсвийн тухай хуульд орж батлагдсан
- Хөрөнгө оруулалтын стратеги төлөвлөгөөг боловсруулах, нэгтгэх, мэдээлэх, тайлагнах, хянах хууль эрхийн акт хангалттай

Бүлэг 2 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэгч сонгох аргыг буруу хэрэглэсэн байна

Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал хөдөлмөрийн салбарт 2008 онд 90 удаагийн нээлттэй тендер шалгаруулалтаар 19.7 тэрбум, 72 удаагийн хязгаарлагдмал тендер шалгаруулалтаар 3.4 тэрбум, 97 удаагийн харьцуулалтын аргаар 2.0 тэрбум, 11 удаагийн шууд гэрээгээр 1.6 тэрбум, өнгөрсөн оны 42 удаагийн худалдан авалтын санхүүжилтэд 5.2 тэрбум, нийт 31.9 тэрбум төгрөгийн худалдан авалт хийжээ. ХАА-ны арга тус бүрийн нийт худалдан авалтын үнийн дүнг графикаар харуулбал:



ХАА-ны арга тус бүрийн нийт худалдан авалтын үнийн дүнг графикаар харуулбал:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийсэн нийт худалдан авалтын 61.7 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 10,7 хувийг хязгаарлагдмал тендер шалгаруулалтаар, 6.5 хувийг харьцуулалтын аргаар, 5.1 хувийг шууд гэрээгээр хэрэгжүүлж, нийт санхүүжилтийн 16.0 хувиар өнгөрсөн оны худалдан авалтыг санхүүжүүлсэн байна.

2.1.ЭМ-ийн салбарт худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод байх зарчим алдагдсан байна

- ЭМЯ 2008 оны ХАА-ны төлөвлөгөөг 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр СЯ-нд хүргүүлж, ХАА-ны цахим хуудаст байршуулсан боловч өдөр тутмын сониноор зарлаагүй байна.
- ЭМЯ Баян-Өлгий, Төв аймгуудад баригдах Спорт цогцолбор зэрэг 7 барилга угсралтын гүйцэтгэгчийг сонгох тендерийн үнэлгээний үр дүнг СЯ-аар хянуулаагүй нь хуулийн 53.2.2 дахь заалтыг зөрчжээ.
- ЭМЯ ХАА-ны цахим хуудсанд мэдээлэх шаардлагатай 60 урилга нийтэлж, түүний зөвхөн 22 хувь буюу 13 тендерийн үр дүнг нийтэлсэн нь хуулийн 21.4, Засгийн газрын 2007 оны 42 дугаар тогтоол, Сангийн сайдын 2006 оны 55 дугаар тушаалаар

батлагдсан журмыг зөрчсөн байна.

- ЭМЯ харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаараас давсан худалдан авалтад, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хувьд тухай бүр, барилга, байгууламжийн угсралт, засварын ажлын гүйцэтгэгчийг сонгох тендерийн хувьд үнийн дүнгээр нь багцалж ЭМЯ-ны ТНБД-ын 2008 оны 38,39, 40,41 дүгээр тушаалаар 4 удаа гүйцэтгэгчийг сонгох үнэлгээний хороо байгуулжээ. Дээрх үнэлгээний хороод ажлын бүрэлдэхүүнд орсон хүмүүсийг өөрчлөөгүй нь тэднээс өөр барилгын мэргэжлийн хүн байхгүйтэй холбоотой байна.

2.2.НХХ-ийн салбарт ХАА-ны гүйцэтгэгч сонгох аргыг буруу хэрэглэсэн байна

Захиалагч нээлттэй тендер шалгаруулах ёстой худалдан авалтыг шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгэгчийг сонгож, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.1.1-дэх заалтыг зөрчиж байна.

- ХНМӨСҮТ-ийн даргаар ажиллаж байсан Б.Туяа тавилга эд хогшилд батлагдсан 32.9 сая төгрөгийг шууд гэрээгээр өөрийн үүсгэн байгуулсан “РБТУ” ХХК-ийн дансанд шилжүүлж, Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмын “Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж зөрчиж гэрээ байгуулсан төсөл арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Үүний зэрэгцээ тус төвийн барилгын засварын ажлыг гүйцэтгүүлэхээр “Намсрайн тахил” ХХК-тай 39.8 сая төгрөгийн гэрээ хийсэн боловч хувь хүмүүсээр хийлгэж ажлын төсөв, гүйцэтгэлийг хуурамчаар үйлдсэн, мөн лабораторт шаардагдах эмнэлгийн тоног төхөөрөмж авахад 82.8 сая төгрөг батлагдсанаас 47.9 сая төгрөгөөр ажлын шаардлага хангахгүй эмнэлгийн тоног төхөөрөмжийг хувь хүнээс худалдан авсан байна.

Худалдан авалтын гэрээг байгуулахдаа тухайн гүйцэтгэгчийн ажлын туршлага, санхүү, ажиллах хүч болон техник, тоног төхөөрөмжийн нөөц боломжийг дутуу үнэлж, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 15,16-д заасан “тендерт оролцогчийн санхүүгийн, техникийн чадавхи болон туршлагыг үнэлэх нотолгоогүйгээр” сонгосон зөрчил илэрлээ.

Баянгол дүүргийн НДХ-ийн конторын өргөтгөлийн барилга угсралтын ажлын тендерт “Бетон, төмөр бетон барилгын ажил”-ын тусгай зөвшөөрөлгүй “Баасан трейд” ХХК-ийг шалгаруулж, 415.0 сая төгрөгийн гэрээ хийсэн байна.

2.3. ХАА-г хуулийн хугацаанд тайлагнах явдал хангалтгүй байна

ЭМЯ, НХХЯ-д худалдан авах ажиллагаа бүрт хавтаст хэрэг бүрдүүлээгүй нь тендерийн хуулийн 49.1 дэх заалтыг зөрчиж байна.

ЭМЯ тендерт оролцогчдын ирүүлсэн тендерийг хавтаст хэрэг болгосон ч түүнийг архивын нэгж болгоогүй, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний тусгай нөхцөл, жил бүр төсөв нэмж батлуулж буй барилга объектын шинэчилсэн төсөв, түүнийг хянаж батлахтай холбоотой материал, тендерт ялагдсан компани ЭМЯ, СЯ болон Захиргааны хэргийн шүүхэд гаргасан гомдол зэрэг материалууд хавтаст хэргээс тусдаа хадгалагдаж байна. Мөн хөрөнгө оруулалтын санхүүжилттэй холбоотой

материалыг үдсэн боловч эмх цэгцгүй, хуудасны дугааргүй, товъёог байхгүй, архивын нэгж болгоогүй байна.

НХХЯ болон түүний харъяа ХНМӨСҮТ-д тендер шалгаруулалтын хавтаст хэргийг бүрдүүлээгүй, зарим худалдан авах ажиллагаатай холбоотой баримт алга байна.

СЯ-наас ТЕЗ-дын 2008 оны ХАА-ны хэрэгжилтэд өгсөн үнэлгээгээр ЭМЯ 87 оноо, НХХЯ 76 оноогоор тус тус “сайн” үнэлгээ авсан боловч ХАА-г хуулийн хугацаанд үнэн зөв тайлагнах явдал хангалтгүй байлаа.

- ЭМЯ ХАА-ны тайланг хугацаанд нь СЯ-д хүргүүлсэн боловч түүнд орон нутгийн болон нэгдсэн эмнэлгүүдийн тайлан нэгтгэгдээгүй байна.
- НХХЯ-ны харъяа зарим байгууллага, ХНМӨСҮТ-өө ХАА-ны тайлангаа хүргүүлээгүй байна.

Иймд тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг гаргаж, холбогдох газарт хүрүүлэх, тендерийн баримт бичгийг бүрдүүлэн архивын нэгж болгон хадгалах шаардлагатай байна.

Шалгах хуудсаар авсан асуулгын дүн ЭМ, НХХ-ийн салбарт хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатайг харууллаа.

Нийт 145 асуулгын дүнг нэгтгэхэд 59.3 хувь нь сөрөг, 40.7 хувь нь эерэг хариулт өгчээ.

Сөрөг хариултын дийлэнхийн үндэслэлийг жагсаавал:

- ХАА-г хуулийн хугацаанд тайлагнаагүй
- ХАА-ны төлөвлөгөөг өдөр тутмын сониноор тогтоосон хугацаанд зарлаагүй
- СЯ-наас зөвшөөрөл авсан тендерийн үнэлгээний үр дүнг хянуулаагүй
- ХАА-ны цахим хуудсанд мэдээлсэн тендерийн үр дүнг нийтлээгүй
- Эсрэг саналтай гишүүдийн тайлбарыг бичиж гарын үсэг зурдаагүй, захиалагчаас нэмж ирүүлсэн тайлбар тодруулгыг бүртгэж, хадгалаагүй
- Харьцуулалт амжилтгүй болсноос гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэсэн
- Бараа ажил үйлчилгээг ижил төстэй байдал, газар зүйн байдлыг харгалзан хэд хэдэн багцад хувааж тендер зарласан
- Захиалагч зардал болон үр ашгийн тооцоог үнэ дээр нэмж тооцоогүй
- Тендерийн баримт бичгийг батлагдсан жишгийн дагуу боловсруулаагүй
- Тендер нь ТББ-т заасан санхүүгийн болон техникийн чадавхийг хангаагүй
- Тендер шалгаруулалтад хөндлөнгөөс нөлөөлсөн
- Захиалагч тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгалаагүй
- Архивын нэгжид шаардлагатай баримт бичгийг бүрэн хамруулж хадгалаагүй

Эерэг хариултын олонхийн үндэслэлийг жагсаавал:

- Үнэлгээний хороог ХА тус бүрт байгуулсан
- Үнэлгээний хороо хурлын тэмдэглэл хөтөлж гарын үсэг зурсан
- Тендерийг үнэлэхдээ үнийг шалгуур үзүүлэлт болгон авч үзсэн
- Захиалагч хуулийн дагуу шаардлагад нийцээгүй тендерээс татгалзсан
- Санхүүжилттэй холбоотой бусад баримт бичгийг хадгалсан
- Үнэлгээний хорооны ихэнх гишүүд ХАА-р мэргэшсэн


Бүлэг 3

Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай байна

2008 онд эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт 43.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 51.3 хувийг Улсын төсвийн хөрөнгөөр, 16.5 хувийг Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр, 5.8 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр, 16.6 хувийг гадаадын зээл, тусламжаар, 4.0 хувийг өөрийн хөрөнгөөр, 5.8 хувийг бусад эх үүсвэрээс тус тус санхүүжүүлсэн байна.

3.1. Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай байна

Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журамд гэрээний үнийн дүнгээс баталгаат засварын хугацаанд гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах харилцааг тусгаагүйгээс гүйцэтгэгчтэй хийх гэрээнд үнийн дүнгээс барьцаа үлдээх талаар заадаг ч эцсийн санхүүжилтээс хэрхэн суутгаж үлдээх, түүнийг хаана ямар дансанд байршуулах, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд тэр барьцааны хөрөнгийг хэрхэн зарцуулах асуудал зохицуулагдаагүй орхигдсон байна. Тухайлбал,



ЭМЯ, "Мандал-Алтай" ХХК-ийн хооронд байгуулсан Говь-Алтай аймгийн спорт заалны засварын ажлын гэрээний тусгай нөхцөлд Барилгын тухай хуулийн 8.3-т заасны дагуу чанарын баталгаат хугацаа 365 хоног, барьцаа хөрөнгийн хэмжээ 5 хувь, урьдчилгаа төлбөр 30 хувь байхаар заасан байна. Гэвч ажил хүлээлцэхэд барьцааны 8.3 сая төгрөгийг санхүүжилтээс суутгаагүй нь баталгаат засварын хугацаанд гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалсан эвдрэл гэмтэл гарах тохиолдолд түүнд засвар хийх хөрөнгийн эх үүсвэргүй болгожээ.

Захиалагч тал гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, тендер зарлахдаа цаашид гарах үр дагаврыг тооцоогүй зөрчил илэрлээ.

Эмнэлгийн хог хаягдлыг устгах цэгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерт “Адил-Оч”, “Норбу” ХХК-үүд шалгарч, тоног төхөөрөмжүүдээ гэрээний дагуу бэлэн болгож, хүлээлцэх баримт бичиг үйлдэж санхүүжилтийг бүрэн олгосон ч суурилуулах байр бэлэн болоогүйгээс нийлүүлэгчийн хашаанд хадгалагдаж байна.



Иймд “Адил-Оч” ХХК, “Норбу” ХХК-даас 235.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг яаралтай хүлээн авч, хог хаягдлын цэгт суурилуулж ашиглалтад оруулах шаардлагатай байна.

- Нийслэлийн 2 дүүрэгт түргэн тусламжийн төвийн барилга барих асуудал шийдэгдээгүйгээс 30 ширхэг богино долгионы станц, түргэн тусламжийн бусад техник, тоног төхөөрөмж агуулахад ашиглалтгүй;
- ЭМ-ийн салбарт АНУ, Герман, Япон, Солонгос зэрэг орнуудаас тоног төхөөрөмжүүд худалдан авч суурилуулах, ашиглах явцад тухайн техникийн талаарх мэдлэг дутмагаас ХСҮТ болон Дундговь зэрэг аймагт зарим тоног төхөөрөмж ашиглалтгүй;
- Ховд аймгийн Ахмадын өргөөний тоног төхөөрөмжид зориулан 39 нэрийн 29.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж техник хэрэгсэл, тавилга эд хогшил олгосноос 32 нэрийн 21.1 сая төгрөгийн тавилга эд хогшил, техник хэрэгслийг хүлээн авсан боловч барилга баригдаагүйгээс агуулахад ашиглалтгүй хадгалагдаж байна.

Хөрөнгө оруулалтын шинж чанартай биш үнэ багатай дагалдах хэрэгслүүдийг хөрөнгө оруулалтын зардлаар бэлтгэж, урсгал зардлаас хөрөнгө оруулалтын шинж чанартай хөрөнгүүд худалдан авчээ. Тухайлбал:

- Улын клиникийн төв эмнэлэг эмийн зардлаас 341.0 сая төгрөгөөр лабораторийн бүрэн автомат тоног төхөөрөмж;
- жижиг эд хогшил бэлтгэх зардлаас 99.1 сая төгрөгөөр 3 нэрийн эмнэлгийн тоног төхөөрөмж тус тус худалдан авсан байна.

Хөрөнгө оруулалтын чанартай зүйл гэдэгт ямар бараа, ажил үйлчилгээг хамруулах талаар тодорхой удирдамж, заавар дутагдаж байна.

3.2. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх, түүний үр дүнг үнэлэх, хариуцлага тооцох тогтолцоо байхгүйгээс гэрээний хэрэгжилт хангалтгүй байна

ТБОНӨХБАҮХАТХ-д зөвхөн захиалагчийн эрх үүргийг зааж, гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг тусгаагүйгээс гүйцэтгэгч байгууллага хариуцлага хүлээхгүй байна.

Худалдан авах ажиллагааны тайланд эмнэлгүүдэд хүлээлгэн өгснөөр тайлагнасан эмнэлгийн зарим тоног төхөөрөмж ашиглагч байгууллагад очоогүй байна. Тухайлбал, 2008 онд нийлүүлэх 7 нэрийн 711.1 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг 7 эмнэлэгт хугацаанд нь хүлээлгэн өгөөгүй байна.

Энэ бүхэн нь төсвийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байгаа тул цаашид гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх зүйн орчинг шинэчлэх шаардлагатай байна.

ҮАГ-аас 2007 онд “Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2006 онд бараа ажил үйлчилгээ худалдан авсан байдал”-д хийсэн аудитаар худалдан авах ажиллагааны үр дүнг гэрээ тус бүрээр төсөв, гүйцэтгэлийг харьцуулан үнэлэлт, дүгнэлт өгөх аргачлал боловсруулж мөрдүүлэх зөвлөмжийг Сангийн яаманд өгсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

- Чингэлтэй дүүргийн ЭМНэгдэлд “Далай техник” ХХК 20.0 сая төгрөгийн үнэ бүхий 6 нэр төрлийн эмнэлгийн багаж аппаратыг 2008 оны 12 дугаар сард нийлүүлэхээр гэрээ байгуулсан боловч нийлүүлээгүй байна.
- Эмнэлгийн барилга ашиглалтад ороогүйгээс Баянхонгор аймгийн Баацагаан сумын эмнэлэгт ЭМЯ-наас хуваарилсан 7 нэр төрлийн 2318.1 мянган төгрөгийн эмнэлгийн багаж төхөөрөмжийг өнөөг хүртэл аваагүй байна.

ЭМЯ-ны ХСҮТ-д эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийн зарим компанитай хийсэн гэрээний үнэ өөрчлөгдсөн байна.

ХСҮТ-д эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерт шалгарсан “Меджей” компанийн тендерийн үнээс гэрээний үнийг 7.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 41.1.2-т заасан заалтыг зөрчсөн байна

ЭМ болон НД-ын байгууллагад хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн чанарт тавих хяналт сул, гэрээний биелэлтийг дүгнээгүйгээс гэрээт ажлууд хугацаандаа хийгдээгүй байна.

- Өмнөговь аймгийн Булган сумын эмнэлгийн барилгыг 2008-2009 онд барихаар тендерт шалгарсан “Говь гурван сайхан” ХХК зөвхөн суурь тавьсан боловч түүнийг буруу тавьснаас МХГ-аас барилгын ажлыг зогсоожээ.
- Дорноговь аймгийн Замын-Үүд дэх НДХ-ийн конторын барилга гэрээ ёсоор 2008 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ашиглалтад орох ёстой боловч 2009 оны 1 дүгээр сард ашиглалтад орсон, хугацаа хэтрэлтийн торгууль, алданги, гэрээний хариуцлагыг тооцоогүй байна.
- Өвөрхангай аймгийн Спорт цогцолборын барилга угсралтын ажлын гүйцэтгэгч “Дорнын өргөө” ХХК барилгыг 2008 оны 6 сард хүлээлгэн өгөх ёстой ч санхүүжилтийн асуудлаас шалтгаалж өнөөг хүртэл дуусгаагүй байна.

НД-ын салбарын хугацаандаа ашиглалтад өгөөгүй төсөл, арга хэмжээг хүснэгтээр үзүүлбэл:

Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (сая төг)	Гүйцэтгэгчид олгосон (сая төг)	2009 оны 1-р сарын байдлаар		
			Хугацаа		Ашиглалтад орсон эсэх
			Эхлэх	Дуусах	
Завхан аймгийн НДХ-ийн конторын БУА	220,0	140,0	2007.09.10	2007.11.20	үгүй
Баянгол дүүргийн НДХ-ийн конторын өргөтгөлийн БУА	415,0	383,5	2008.02.25	2008.08.22	үгүй
Дорноговь аймгийн НДХ-ийн конторын БУА	136,0	136,0	2008.04.14	2008.06.30	2009.01 сард
Ховд аймгийн НДХ-ийн конторын БУА	200,0	277,8	2008.06.02	2008.09.27	2008.12.22
Увс аймгийн НДХ-ийн конторын БУА	200,0	200,0	2008.05.29	2009	үгүй

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 41.2-т заасныг зөрчиж УНДЕГ Хөвсгөл, Баян-Өлгий аймгуудын НДХ-т хуучин Ланд круизер автомашиныг 15.0 -21.0 сая төгрөгөөр нийлүүлэхээр “Межик товер”, “Соёмбо пресс” ХХК-иудтай гэрээ байгуулсан боловч төлбөрийг Дундговь аймгийн “Бүрдийн домог”, Баян-Өлгий аймгийн “Нью

фруйт” компаниуд руу шилжүүлсэн байна. Ийнхүү гэрээний хугацаанд үндсэн гүйцэтгэгчийг сольсон байна.

3.3.ЭМ-ийн салбарт гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй байна

- *Нийслэлийн Хан-Уул, Багануур, Чингэлтэй дүүргийн ЭМН-үүдэд хийсэн засварын чанар муу хаалганы бариулууд унасан, шаланд нимгэн хулдаас нааснаас үрчийсэн, дээврээс ус алдсан зэргээр чанарын шаардлага хангахгүй байна.*
- *Ховд аймгийн төвд баригдах Усан спортын төвийн барилгын зургийг БНХАУ-ын ШУӨЗО-ны Урумчи хотын зургийн байгууллагад хийлгэсэн боловч суурийн ажлын зураг дутуу ирснээс барилга угсралтын ажлын тендерт шалгарсан “ББМЗЗТ” ХХК барилгын ажил хийх боломжгүй болоод байна.*
- *Сэлэнгэ аймгийн Баянгол, Баруунбүрэн, Орхон сумын эмнэлгүүд, БГХӨСТ-ийн засварыг чанар муутай гүйцэтгэснийг эргэж засахыг шаардсан ч арга хэмжээ аваагүй бөгөөд гүйцэтгэгчтэй хариуцлага тооцож чадаагүй байна.*

Энэ нь ашиглагч байгууллагын төлөөлөл төсөл арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт тавих, ажил хүлээлцэх комиссын бүрэлдэхүүнд оролцдоггүйтэй холбоотой байна.

Захиалагч гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, гүйцэтгэлийг үнэлэх, хариуцлага тооцох үйл явц холбогдох хууль тогтоомжийн дагуу үр нөлөөтэй хэрэгжиж байна уу гэсэн асуудлаар ЭМ, НХХЯ, тэдгээрийн харъяа байгууллагуудаас авсан нийт 97 асуулгын дүнг нэгтгэхэд 77.3 хувь нь сөрөг, 22.7 хувь нь эерэг хариулт өгчээ.

Сөрөг хариултын дийлэнхийн үндэслэлийг жагсаавал:

- *Захиалагч гүйцэтгэгчийн хороонд байгуулсан гэрээг батлагдсан загварын дагуу байгуулаагүй*
- *Гэрээнд хариуцлага тооцох талаар тодорхой зааж өгөөгүй*
- *Гүйцэтгэгч нь тухайн ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлгүй*
- *Тухайн байгууллага нь шууд гэрээ байгуулсан, үнийн дүнд өөрчлөлт оруулсан*
- *Гэрээний гүйцэтгэлийг үнэлэх тусгай шалгуур үзүүлэлт байхгүй*
- *Гэрээний гүйцэтгэлийн явцад техникийн хяналт байнга тавьж чадаагүй*
- *Гэрээний гүйцэтгэлийг үнэлсэн талаар дүгнэлт гаргаж, баримтжуулаагүй*
- *Захиалагч үндсэн гүйцэтгэгчийг солих болсон шалтгааныг судалж баримтжуулаагүй*
- *Гэрээний хугацаанд үндсэн гүйцэтгэгчийг солихдоо хүлээх, үүрэг, хариуцлагыг тусгасан гэрээ байгуулаагүй*
- *Захиалагч нь гэрээ тус бүрээр гэрээний биелэлтийг гаргаагүй*
- *Гэрээний биелэлтэд тогтмол үнэлгээ хийдэггүй*
- *Үнийн өөрчлөлтийг гэрээнд тусгаагүй*
- *Гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд хариуцлага тооцох арга хэмжээ авдаагүй*
- *Гүйцэтгэгчийн буруугаас болсон хохирлыг тогтоож, хариуцлага тооцоогүй*

Эерэг хариултын олонхийн үндэслэлийг жагсаавал:

- *Гэрээний гүйцэтгэлийг үнэлэх, хянах ажлын хэсгийг томилсон*
- *Хяналтын ажлыг төв, орон нутгийн мэргэжлийн байгууллагатай хамтран хийсэн*
- *Гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичгийг баримтжуулсан*
- *Гүйцэтгэгчийн гаргасан урьдчилгаа төлбөрийн баталгааг захиалагч хянасан*

Бүлэг 4 Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн тогтолцоо оновчгүй байна

4.1. Санхүүжилт олгож буй өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна

Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.4-т “Захиалагчийн хянаж баталгаажуулсан барилгын ажлын гүйцэтгэл, барилга, их засварын ажлыг ашиглалтад хүлээн авсан тухай улсын болон орон нутгийн комиссын актыг үндэслэн санхүүжилт олгох ёстой” гэж заасныг ЭМ-ийн салбарт жигд мөрдөн ажиллахгүй байна. Тухайлбал,

- Баянхонгор аймгийн Баацагаан сумын 10 ортой эмнэлгийн барилгыг “Өрнөх хурд” ХХК барьж 2008 оны 12 дугаар сарын 15-нд аймгийн улсын комиссын актаар хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон боловч ашиглалтад ороогүй байна.
- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын өрхийн эмнэлгийн барилгын ажилд 150,0 сая төгрөг батлагдаж, гадна тохижилтын ажлын гүйцэтгэлийг хуурамчаар гаргасан байхад санхүүжилтийг бүрэн олгосон.
- Өмнөговь аймгийн Ноён сумын эмнэлгийн засварыг дуусаагүй байхад улсын комиссын акт үйлдсэн байна.
- ЭМЯ-наас Архангай аймгийн Халдвартын эмнэлэг, Баянхонгор, Ховд аймгийн төвд баригдах 50 ортой төрөхийн эмнэлгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчидтэй 2008 оны 12 дугаар сард гэрээ байгуулж, барилгын материал худалдан авсан, тээврийн хөлс зарцуулснаар гүйцэтгэл гаргаж ирүүлснийг үндэслэн тухайн сард санхүүжилтийг бүрэн олгожээ.

Дээрх байдал нь оны эхнээс тендерийн бэлтгэл ажил хийгдэж, гэрээ хийх ажиллагаа явагдсаар цаг алдаж батлагдсан санхүүжилтийг ондоо багтааж зарцуулах үүднээс жилийн эцэст олон тооны барилга байгууламжийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгодогтой холбоотой байна. Тухайлбал, ЭМЯ-наас олгож буй хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 39.9 хувийг 11-12 дугаар сард олгосон байна.

Иймд төсвийн жилийг хуанлийн жилээс ялгавартай тогтоох асуудлыг судалж үзэх нь зүйтэй байна.

Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулахын оронд ЭМЯ, НХХЯ болон НД-ын байгууллагууд том оврын, шатахуун их зарцуулдаг суудлын автомашин худалдан авч хэрэглэж байна.

- НХХЯ “МОННИС Интернэшнл” ХХК-тай “Ниссан” маркийн 46,0 сая төгрөгийн суудлын автомашиныг сайдын албан хэрэгцээнд худалдан авахаар шууд гэрээ байгуулжээ. Яам, агентлагийн автомашиныг худалдсаны орлогыг хэрхэн зарцуулах талаар зохих шийдвэр гараагүй байхад Төрийн өмчийн хороо 2008 онд 64 дүгээр тогтоол гарган автомашины үнэд дээрх орлогоос 38,7 сая төгрөгийг тус компанид эрх мэдлээ хэтрүүлэн олгожээ.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан яаралтай түргэн тусламжийн автомашин авах хөрөнгөөр ЭМЯ ажлын албанд 3 ширхэг суудлын автомашиныг 206.4 сая төгрөгөөр худалдан авч хөрөнгө оруулалтын зориулалтыг өөрчилсөн байна.

ЭМЯ, НХХЯ болон НД-ын байгууллагууд 2008 онд батлагдсан төлөвлөгөөг хэтрүүлэн суудлын автомашин худалдан авсныг хүснэгтээр харуулбал, сая төгрөгөөр

Байгууллагын нэр	Автомашины нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
ЭМЯ	Ниссан, Ланд 200		206.4	206.4
НХХЯ	Ниссан		44.6	46.0
СХД ХХҮХ	Старекс		10.0	10.0
Ховд аймгийн НДХ	УАЗ 31519	15,0	15,8	0,8
Баян-Өлгий НДХ	Ланд 80	15,0	21,0	6,0
Завхан НДХ	Ланд 80	15,0	21,0	6,0
Дархан-Уул НДХ	Ланд ровер	15,0	17,6	2,6
Нийслэлийн НДГ	Волсваген	10,0	28,0	18,0
Дундговь НДХ	Ланд 80		15,0	15,0
Хөвсгөл НДХ	Тоёото прадо	15,0	18,5	3,5

Дээрх арга хэмжээний батлагдсан төлөвлөгөөнөөс давсан эх үүсвэрийг НХХЯ, СХД-ийн ХХҮХ тоног төхөөрөмж авахаар батлагдсан төсвөөс, НД-ын байгууллагууд НДҮЗ-ийн 2001 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу тус тус зарцуулсан байна.

Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.8-д “Зураг төсөв, техник-эдийн засгийн үндэслэл, тооцоо боловсруулахад урьдчилгаа санхүүжилт олгохгүй” гэж заасныг зөрчин зураг төсөв боловсруулах ажилд урьдчилгаа олгожээ. Тухайлбал,

- Нийслэлд баригдах 300 ортой төрөхийн эмнэлгийн барилгын зураг төсвийг боловсруулж буй ООО “Дарханстрой”-той гэрээ байгуулсан өдрөөс хойш 5 хоногийн дотор гэрээний үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх санхүүжилт олгожээ.
- Шадар сайдын төсвөөс НХХЯ-ны харъяа ХНМӨСҮТ-д эмнэлгийн барилгын зураг, төсвийн 18.0 сая төгрөг батлагдсан ба тус төв худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг зөрчин гүйцэтгэгчид 9,0 сая төгрөгийг шилжүүлсэн ба үлдээгдэл 9,0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Төв аймгийн спорт цогцолборын зураг төсөв боловсруулах гэрээг “Хөх бичээч” ХХК-тай байгуулж, урьдчилгаа 7.2 сая төгрөгийг 3 хоногт багтаан олгохоор гэрээнд заажээ.

ЭМ-ийн салбарт хөрөнгө оруулалтын нэг төсөл арга хэмжээ хэд хэдэн эх үүсвэрээс зэрэг санхүүжих тохиолдол байна.

- Төв аймагт баригдаж буй Халдварт сүрьеэгийн 30 ортой эмнэлгийн барилга угсралтын ажлыг 389.8 сая төгрөгт багтаан хийх гэрээг 2008 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр байгуулсан. Гэвч төсөвт өртөг нэмэгдэж 600.0 сая төгрөг болж байгаа гэдэг үндэслэлээр ЭМЯ-наас Дэлхийн зөн ОУБ-т нэмэлт 200.0 сая төгрөгийн санхүүжилт авах санал боловсруулан тавьсан байна.
- Архангай аймагт баригдаж буй Халдварт сүрьеэгийн 30 ортой эмнэлгийн гэрээний дүн 599.5 сая төгрөг ба үүний 449.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 150.0 сая төгрөгийг Дэлхийн зөн ОУБ-аас санхүүжүүлэх гурвалсан гэрээг 2008 оны 12 дугаар сарын 5-ны өдөр байгуулжээ.
- Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгонд зураг төсөв нь бэлэн болоогүй олимпын

бэлтгэлийн төвийн барилга барих 1250.0 сая төгрөгийн гурвалсан гэрээг 2007 оны 8 дугаар сарын 1 ний өдөр БТСУХ, МҮОХ, Нийслэл өргөө ХК-ийн хооронд байгуулсан байна. Засгийн газрын 2007 оны 249 дүгээр тогтоолоор 250.0 сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс 500.0 сая төгрөгийг 2008 оны улсын төсвөөс, үлдэх 500.0 сая төгрөгийг МҮОХороо санхүүжүүлэхээр гэрээгээр үүрэг хүлээсэн байна.

4.2.ЭМ-ийн салбарт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж буй ажилтнуудын хоорондын ажлын уялдаа холбоо оновчтой биш байна

ЭМ-ийн сайдын 2003 оны 71 дүгээр тушаалаар ЭМЯ-ны Барилга захиалагчийн албыг байгуулж, ТӨААТҮГ статустай аж ахуйн нэгж болгожээ.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 20 дугаар зүйлд “энэ хуулиар зохицуулагдаагүй бусад харилцааг Компанийн тухай хуулиар зохицуулна” гэж заасныг дагаж мөрдөөгүйгээс тус албаны орлого зарлагын төлөвлөгөөг баталдаг, тайлан балансыг авч хэлэлцдэг газар байхгүй байна. **Иймд тус албыг Сангийн яамны бүтэцэд Барилга захиалагчийн газар хэлбэрээр нэгтгэх асуудлыг судалж шийдвэрлэх хэрэгтэй байна.**

ЭМЯ-ны Төрийн сан дахь Хөрөнгө оруулалтын харилцах данснаас 2008 онд БЗА-д 301.0 сая төгрөг шилжүүлснийг 105.0 сая төгрөгийг нь орлогоор, 195.0 сая төгрөгийг нь өглөгөөр бүртгэжээ. 2008 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан өглөгийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.4-д”...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэснийг зөрчсөн байна.

ЭМЯ-ны санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан ажилтнууд аудитад шаардлагатай хөрөнгө оруулалтын судалгааг хугацаанд нь үнэн зөв гаргаж ирүүлээгүйгээс нэгдсэн эмнэлгүүд болон аймгуудын судалгааг аудиторуд аудитын явцад нэгтгэлээ.

Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1-д “Аж ахуйн нэгж ,байгууллага нь хөрөнгөө ... Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын дагуу үнэлж, дансанд тусгана” гэж заасныг зөрчиж, ашиглалтад хүлээн авсан барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмжийг санхүүгийн бүртгэл, тайлан тэнцэлд тусгаагүй байна.Тухайлбал,

- ЭМЯ 2008 оны эцэст “БСБ Сервис” ХХК-иас хүлээн авсан 8.2 сая төгрөгийн үнэ бүхий 12 ширхэг агааржуулагчийн зориулалтыг өөрчлөн яамны өрөөнүүдэд суурилуулсан боловч нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байв.
- Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрийн барилгын засварт 115.0 сая төгрөг, ХХХСҮ-ийн өргөтгөлийн ажилд зарцуулсан 148.2 сая төгрөг, нийт 263,2 сая төгрөгийг санхүүгийн тайланд 6.2 сая төгрөгөөр дутуу тусгасан.
- СХД-ийн ХХҮХ-ийн 268.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хандиваар бүртгэж, тоног төхөөрөмж худалдан авахад зориулан 89.5 сая төгрөг батлагдсанаас 10.0 сая төгрөгийн суудлын автомашин худалдан авсан, санхүүгийн тайланд тоног төхөөрөмж болон засварын ажлын зардлыг 0.4 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан.
- Өмнөговь аймгийн нэгдсэн эмнэлэг ЭМЯ-наас хуваарийн дагуу олгосон эмнэлгийн тоног төхөөрөмжийг 57.1 сая төгрөгийн илүү үнээр орлого болгосон, 1.6 сая төгрөгийн хүчил төрөгч өтгөрүүлэгчийг бүртгэлд тусгаагүй байна.

4.3.НХХ-ийн салбарт хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үе шатны ажилд үр нөлөөтэй байнгын хяналт тавиагүй байна

Сангийн сайдын 2008 оны 58 тушаалаар батлагдсан журмын 4.1-д “Захиалагч нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажлыг явуулах, түүнд техникийн хяналт тавих, шалгалт хийх, ашиглалтад хүлээн авах ажлыг барилгын салбарт мөрдөж байгаа хууль болон барилгын салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан норм, дүрэм, журмын дагуу явуулна” гэж заасан.

Дархан-Уул аймгийн Шарын гол суманд барьсан Ахмадын барилгыг улсын комиссоор хүлээж авсан боловч ажлын явцад захиалагч хяналт муу тавьснаас тухайн барилгын хана нурсан, дээврээс ус гоожсон, хаалга цөмөрсөн, шал цонхны тавцан хуурсан зэрэг гологдол гарч барилгыг цаашид ашиглах боломжгүй болжээ.

НХХ-ийн салбарын нийт хөрөнгө оруулалтын 44 хувь буюу 1586.0 сая төгрөгөөр нийслэлийн 3 дүүрэг, 8 аймгийн иргэдэд 2042 гэр олгожээ.

Төв аймгийн зарим сумдад түүвэрчлэн шалгахад чанарын шаардлага хангахгүйгээс зарим гэр хураалттай, ашиглагдахгүй байна. Гэрээгээр иж бүрэн, бага 5 ханатай, шалтай гэр нийлүүлэх ёстой атал 4 ханатай, шалгүй гэр нийлүүлсэн, ам нь нийлдэггүй, нимгэн драккан ханатай, маш нарийхан, муруй тахир уньтайн дээр эсгийг зулхайгаар, брезентийг гялгар цаасаар орлуулсан байжээ.

Иймд нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлэх зохистой тогтолцоо бий болгох нь зүйтэй байна.

Дархан-Уул аймагт 400.0 сая төгрөгөөр Ахмадын байр хоёрыг бариулсан ч ахмадуудад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаггүй, зарим өрөөг хувь хүмүүст үйлчилгээний зориулалтаар ашиглуулж, зарим нь ашиглалтгүй байгаа нь улсын төсвийн хөрөнгийг үр ашиг, ач холбогдол багатай, зайлшгүй шаардлагатай бус зүйлд зарцуулж байгааг харуулж байна.

ЭМЯ гадаадын зээл тусламжаар хийж буй хөрөнгө оруулалтын ирээдүйн үр өгөөжийг тооцох шаардлагатай байна.

- ЭМСХ-2” хөтөлбөрийн сахүүжилтээр Баянхонгор аймгийн Жаргалант суманд баригдсан амбулаторийн барилгын дотор ханын шавардлага зарим хэсэгтээ хагарч нурсан, халаалт муу, эмчийн орон сууцны гадна ханын шавардлага бүхэлдээ хагарсан, Баянговь сумын эмчийн орон сууц дээврээс дусаал гоожсон, зарим хэсгээрээ цоорхойтой, дээрх хоёр орон сууцны барилга ашиглалтад хүлээн авсан боловч одоо болтол ашиглагдаагүй байна.
- Завхан аймгийн Отгон суманд барьсан 15 ортой эмнэлгийн барилга стандартын шаардлагын дагуу баригдаагүй, сантехникийн холболт буруу, хана тааз нурсан, шал товойсон, чанарын шаардлага хангахгүй байна.

Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн тогтолцооны талаар авсан нийт 97 асуулгын дүнг нэгтгэхэд 69.1 хувь нь сөрөг, 30,9 хувь нь эерэг хариулт өгчээ.

Сөрөг хариултын дийлэнхийн үндэслэлийг жагсаавал:

- *Захиалагчийн объект нэг бүрийн ажлын баталгаажсан гүйцэтгэлийг үндэслэн санхүүжүүлээгүй.*
- *Хөрөнгийг хууль ёсоор зориулалтын дагуу зарцуулаагүй.*
- *Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавиагүй*
- *Тайлант онд бүрэн зарцуулаагүй үлдэгдэл мөнгийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй*
- *Санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээ, ажлын явцын талаарх мэдээллийг гаргаагүй*

Эерэг хариултын олонхийн үндэслэлийг жагсаавал:

- *Ажлын гүйцэтгэл, холбогдох баримт нь зохих журмын дагуу бүрэн ирсэн байхад эрх нээгээгүй, санхүүжилтийг хугацаанд нь хийсэн.*
- *Яам, газар захиалагчийн объект бүрийн гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилтийн эрхийг нээсэн*
- *Сангийн яам санхүүжилтийг хугацаандаа хийсэн*

Аудитаар 89,8 сая төгрөгийн төлбөрийн акт бичиж, 510,3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өглөө.

Захиалагч төсөл арга хэмжээ бүрээр үе шатны ажилд байнгын хяналт тавиагүй, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцоогүй бөгөөд цаашид хяналтыг үр ашигтай, үр нөлөөтэй зохион байгуулах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарт хөрөнгө оруулалтын дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж мөрдөөгүйгээс зураг, төсөвгүй олон тооны барилга байгууламж төсөвт тусгагдсан нь түүний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлжээ.
- НХХ-ийн салбарт 2008 оны Төсвийн тухай хуульд тусгагдаагүй төсөл, арга хэмжээг нэмж оруулсан, санхүүжилтийн эх үүсвэрийг өөрчилсөн, их засварын зардлыг хөрөнгө оруулалтын зардалд шилжүүлэн зарцуулсан явдал нийтлэг байна.
- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарт тендерийн баримт бичгийг бүрдүүлж архивын нэгж болгон хадгалах, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг хуулиар тогтоосон хугацаанд бүрэн гаргаж хүргүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлан мэдээлэх явдал хангалтгүй байна.
- НХХ-ийн салбарт ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчин шууд худалдан авалт хийсэн, албан тушаалаа хэтрүүлэн ашигласан, худалдан авах ажиллагааны аргыг буруу сонгосон байна.
- Төсөл арга хэмжээний гүйцэтгэгч нартай хийж буй гэрээнд бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат хугацаанд барьцаа хөрөнгө үлдээх тухай заалт оруулах асуудлыг эрх зүйн актаар зохицуулах, барьцааны хөрөнгийг төвлөрүүлэх харилцах дансыг Төрийн санд төсвийн ерөнхийлөн захирагч нар захиран зарцуулах эрхгүйгээр нээж эцсийн санхүүжилтээс тооцоо хийдэг тогтолцоонд шилжих шаардлагатай байна.
- Тухайн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийн ажилд хяналт тавих, ажил хүлээлцэх явцад ашиглагч байгууллагын төлөөллийг оролцуулах тогтолцоог бий болгох шаардлагатай байна.
- ЭМЯ гадаадын зээл тусламжаар хийж буй хөрөнгө оруулалтын ирээдүйн үр өгөөжийг дээшлүүлэх шаардлагатай байна.
- Төсвийн жилийг хуанлийн жилээс ялгавартай тогтоох асуудлыг судалж үзэх нь зүйтэй байна.
- ЭМЯ төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг хуурамчаар гаргаж улсын комиссын акт ирүүлсэн гүйцэтгэгч нарт санхүүжилт олгосны зэрэгцээ гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчидтэй хариуцлага тооцож ажиллаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

Нэг.Сангийн сайд С.Баярцогтод:

- Байршил шийдэгдээгүй, техникийн нөхцөл аваагүй, зураг төсөвгүй барилга байгууламжийг төсөвт тусгах явдлыг зогсоох
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ бүрийн гүйцэтгэгчтэй хийж буй гэрээнд чанарын баталгаат хугацаанд барьцаа хөрөнгийг авах, барьцааны хөрөнгийг Төрийн санд нэгдсэн дансанд төвлөрүүлж эцсийн санхүүжилтээс суутгал хийж, баталгаат засварын хугацаа дуусахад тооцоо хийх тогтолцоо бий болгох.
- Төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийн ажилд хяналт тавих, ажил хүлээлцэх явцад ашиглагч байгууллагын төлөөллийг оролцуулах тогтолцоог бий болгох
- Төсвийн жилийг хуанлийн жилээс ялгавартай тогтоох асуудлыг судалж, зохих асуудал боловсруулж холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх
- Төсвийн ерөнхийлөн захирагчдын дэргэд байгаа БЗА-ыг Сангийн яамны бүтэцэд Барилга захиалагчийн газар хэлбэрээр нэгтгэх асуудлыг судалж шийдвэрлэх.

Хоёр.Эрүүл мэндийн сайд С.Ламбаад:

- Үндэсний хөгжлийн цогц бодлого, эрүүл мэндийн талаар төрөөс барих бодлоготой уялдуулан хөрөнгө оруулалтын дунд хугацааны төлөвлөгөө батлуулж мөрдөх.
- Тендерийн баримт бичгийг бүрдүүлж архивын нэгж болгон хадгалах талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулах.
- Төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг хуурамчаар гаргаж улсын комиссын акт ирүүлсэн болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчидтэй, дахин гэрээ хийхгүй байх зарчмыг баримталж хариуцлага тооцож ажиллах
- Төсөл арга хэмжээний гүйцэтгэл, улсын комиссын актыг хуурамчаар үйлдсэн төрийн албан хаагчдад хариуцлага тооцох

Гурав.НХХ-ийн сайд Т.Гандид:

- Төсвийн тухай хуульд тусгагдаагүй төсөл, арга хэмжээг нэмж оруулах, санхүүжилтийн эх үүсвэрийг өөрчлөх, их засварын зардлыг хөрөнгө оруулалтын зардалд шилжүүлэн зарцуулах, өндөр үнэтэй, шатахуун их зарцуулдаг автомашин худалдан авах явдлыг зогсоох
- Тендерийн баримт бичгийг бүрдүүлж архивын нэгж болгон хадгалах, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг хуулиар тогтоосон хугацаанд бүрэн гаргаж хүргүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлан мэдээлэх тодорхой арга хэмжээ зохион байгуулах.
- ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчин шууд худалдан авалт хийсэн, албан тушаалаа хэтрүүлэн ашигласан этгээдтэй зохих хариуцлага тооцон биелэлтийг гаргаж ҮАГ-т ирүүлэх



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

**МОНГОЛ УЛСЫН НИЙГМИЙН
ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ**

210646 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 5,
утас: 26-15-53, факс: 32-86-34, E-mail: Mswl@mongolnet.mn

2009.06.17 № 3/1462
танай _____-ны № _____-т

Санал өгөх тухай

Үндэсний аудитын газраас нийгмийн хамгааллын салбарын 2008 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилт, түүний үр дүнд хийсэн аудитын дүнтэй танилцлаа.

Салбарын хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг сайжруулж, үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар шинжээчийн өгсөн санал, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж мөрдүүлэх, гэрээний биелэлтэд хяналт тавьж, хариуцлагын тогтолцоог сайжруулах, тендерийн баримт бичгийг хавтаст хэрэг болгон бүрдүүлэх зэргээр цаашид зохих хууль, тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллах болно.

Бидний ажлын алдаа оноог дүгнэж, санал, зөвлөмж өгсөн та бүгдэд талархал илэрхийлье.



ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХЦЭРЭН

08 155



**ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ,
МЭРГЭЖЛИЙН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ**

15172 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Төмөрчний гудамж
3 дугаар хороо, Утас/Факс: (976-11) 32-49-49,
E-mail: rcod@mongol.net

2009.05.26 № 109

танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТИЙН ГАЗАРТ

Манай Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвийн 2008 оны хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд 2009 оны 05 дугаар сард Үндэсний Аудитын газрын шинжээч н.Болормаагийн хийсэн гүйцэтгэлийн аудитын дүн болон зөвлөмжүүдтэй танилцлаа.

Шинжээч н.Болормаагийн гаргасан дүгнэлт, зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна.

Цаашид гарсан алдаа дутагдал, зөрчлийг арилгах, зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр тусгай төлөвлөгөө гарган, дахин зөрчил гаргахгүй байх талаар анхаарч ажиллах болно.

ДАРГА

Д.АТАРМАА

D:\A5.doc



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
E-mail: moh@moh.mn, http://www.moh.mn

2009.06.30 № 5/1835

танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Эрүүл мэндийн салбарын 2008 оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хийгдсэн аудитын шалгалтын тайланд тусгагдах асуудалд өгөх тайлбарыг хавсралтаар гаргаж хүргүүлэв



САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Н.ТҮМЭНДЭМБЭРЭЛ

083147

АУДИТЫН ТАЙЛАНД ТУСГАГДСАН АСУУДАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Аудитын тайланд тусгагдсан асуудал

ЭМ-ийн салбарт 2008 онд 9.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 объектыг нийслэлд барихаар 5.5 тэрбум төгрөг баталсан боловч зураг төсөвгүй, барилга барих газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл аваагүйн улмаас 5.2 тэрбум төгрөг төсвийн тодотголоор хасагдаж, зөвхөн нэг объектын гүйцэтгэгчтэй гэрээ хийсэн байна.

- **Тайлбар:** 2008 оны Улсын төсвийг батлахад Улсын Их хурал дээр гишүүдээс гаргасан саналаар тойрогт оруулах хөрөнгө оруулалтаар батлагдсан барилгууд тул газар олголт, техникийн нөхцөлгүйн улмаас 2008 оны Улсын төсвийн тодотголд яамны саналаар хасаж зохицуулалт хийсэн

- 2008 оны Улсын төсвийн тухай хуульд 650.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр баталсан Ховд аймгийн төрөхийн эмнэлгийн барилгын төсөвт өртгийг 938.0 сая төгрөг болгон нэмэгдүүлж “Ховдын Өргөө” ХХК-тай гэрээ хийсэн ч зураг төсөв бэлэн болоогүй, барилга барих газар чөлөөлөөгүй шалтгаанаар өнөөг хүртэл барилгын ажил эхлээгүй байна.
- Булган аймгийн Хишиг-Өндөр сумын 10 ортой эмнэлгийн барилга гэрээний дагуу 2009 оны 10 дугаар сард ашиглалтад орох байсан боловч Ерөнхий сайд тус суманд ажиллах үеэр иргэдээс 20 ортой болгохыг хүссэний дагуу барилгын ажлыг зогсоож, зураг төсөвт өөрчлөлт оруулах ажил хийгдэж, барилгын ажил эхлээгүй байна.

- **Тайлбар:** Ховд аймгийн 50 ортой төрөх эмнэлгийн барилгын хувьд Зураг төсөв нь бэлэн болоогүй байсан ба 2008 онд зургийн ажил хийгдэж 2009 онд дууссан, одоо ажил нь эхэлсэн 1,5 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан 2008 онд 650,0 сая, 2009 онд 300,0 сая нэмэгдэн 950,0 сая болсон ба 2009 оны Улсын төсвийн тодотголд 600,0 сая нэмж тусгуулахаар санал СЯ-нд хүргүүлсэн

- Булган аймгийн Хишиг-Өндөр сумын эмнэлгийн хувьд Улсын Их хурлын гишүүний тойрогтоо оруулах хөрөнгө оруулалтаар 170,0 сая төгрөг 2008 оны Улсын төсөвт тусгагдсан. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу худалдан авах, ажил гүйцэтгэх, санхүүжүүлэх эрхийг Сангийн сайдын 2008 оны 22 тоот тушаалаар аймгийн Засаг даргад шилжүүлсэн боловч Ерөнхий сайд Булган аймагт ажилласантай холбогдон авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу яамнаас 20 ортой эмнэлгийн барилгын зураг төсвийг шинээр зохиолгон ажлыг эхлүүлсэн ба төсөвт өртгийн зөрүүг ирэх оны төсөвт суулгуулхаар сангийн яаманд санал хүргүүлсэн энэ нь **бас л жил бүрийн төсөвт хөрөнгө нэмүүлэх үндэслэл болж байгаа юм**

Эрүүл мэнд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбар хөрөнгө оруулалтын талаар баримтлах дунд хугацааны бодлого, төлөвлөлт боловсруулж батлаагүй байна. Жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагддаг ирэх 3 жилийн хөрөнгө оруулалтын талаархи төсөөллийн дагуу төсөл арга хэмжээг улсын төсөвт тусгаж иржээ.

Зарим барилга, объектын төсөвт өртгийг үнэ ханшийн өөрчлөлтөөс шалтгаалж нэмэгдүүлсэн байна.

- Увс аймагт баригдаж буй спорт цогцолборын төсөвт өртөг анх 2005 оны 12 дугаар сард хийсэн гэрээгээр 975.0 сая төгрөгөөр батлагдсныг 2007 оны 9 дүгээр сард 1225.0 сая төгрөгөөр, улмаар 2008 оны 11 дүгээр сард 1446.0 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн;
- 2007 оноос шилжиж ирсэн Хөвсгөл аймгийн Жаргалант, Сэлэнгэ аймгийн Бугант, Баянхонгор аймгийн Баацагаан сумдын 10 ортой эмнэлэг зэрэг 11 объектод нэмж шаардагдсан 21.0-110.0 сая төгрөгийн санхүүжилтийг “МУ-ын 2008 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулиар тус тус нэмж баталжээ.
- Завхан аймгийн Идэр суманд “Алс” ХХК-ийн барьж буй 10 ортой эмнэлэгт ЭМСХ-2 төслөөс 114.6 сая, улсын төсвөөс 50.0 сая төгрөгийн санхүүжилт олгосноор хоёрдугаар давхарын өрлөг талдаа орсон ч нэмж 67.5 сая төгрөг, Булган аймгийн Хялганат тосгоны Ахмадын сувиллын барилгын төсөвт өртөг 40.9 сая төгрөг батлагдсаны 90 хувийг гүйцэтгэгчид олгосон боловч нэмж санхүүжилт шаардлагатай гэх шалтгаанаар барилгын ажил зогсчээ.

- **Тайлбар:** Ганц Увс аймгийн спорт цогцолбор биш Өвөрхангай, Хэнтий аймгуудын спорт цогцолборын барилгууд 2005-2009 он хүртэл он дамжин үргэлжилж байгаа тул жил бүрийн төсөвт хөрөнгө тусгагдаж байгаа ба 2009 оны төсөвт Булган, Өвөрхангай аймгийн спорт цогцолборуудад хөрөнгө тавигдаагүйн улмаас энэ онд ажил хийгдээгүй зогсож байгаа ба Засгийн газрын хуралдаанаар уг асуудал яригдан Сангийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг томилон ажиллуулж асуудал боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулхаар бэлэн болгосон ба дутуу хөрөнгө Улсын төсвийн тодотголоор шийдвэрлэдсэн тохилдолд энэ онд уг 2 цогцолбор ашиглалтанд орно.

- 2007 оноос шилжиж ирсэн Хөвсгөл аймгийн Жаргалант, Сэлэнгэ аймгийн Бугант, Баянхонгор аймгийн Баацагаан сумдын 10 ортой эмнэлэг зэрэг 11 объектод нэмж шаардагдсан төсөвт өртгийн зөрүү 21.0-110.0 сая төгрөгийн санхүүжилтийг СЯ-аар хянагдан “МУ-ын 2008 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулиар тус тус нэмж батлуулан ажлыг гүйцэтгэн ашиглалтанд хугацаанд нь оруулсан

- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу Сангийн сайдын 2008 оны 22 тоот тушаалаар аймаг орон нутагт эрх шилжсэн объектуудын мэдээг авч нэгтгэн СЯ-нд мэдээлж байгаа бөгөөд Завханы Идэр, Булганы Хялганат тосгоны ахмадын сувилалын барилгын гүйцэтгэл бүрэн гарч мэдээлэгдсэн

Худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод байх зарчим алдагдсан байна

- ЭМЯ 2008 оны ХАА-ны төлөвлөгөөг 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр СЯ-нд хүргүүлж, ХАА-ны цахим хуудаст байршуулсан боловч өдөр тутмын сониноор зарлаагүй байна.

- **Тайлбар:** Сангийн сайдын шийдвэрээр төсвийн тодотгол хийгдтэл бүх худалдан авалтыг түр хугацаагаар хойшлогдсонтой холбогдон худалдан авах ажиллаганы ерөнхий төлөвлөгөөг хэвлэлд тавиагүй ба төсвийн тодотголоос хойш хийгдсэн бүх худалдан авах ажиллагааны зар төвийн хэвлэл мэдээлэлд тавигдсан

- ЭМЯ Баян-Өлгий, Төв аймгуудад баригдах Спорт цогцолбор зэрэг 7 барилга угсралтын гүйцэтгэгчийг сонгох тендерийн үнэлгээний үр дүнг СЯ-аар хянуулаагүй нь хуулийн 53.2.2 дахь заалтыг зөрчжээ.

- **Тайлбар:** 2008 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөгдсөн ХАА-ны хуулинд орсон нэмэлтийн дагуу 3,0 тэрбум төгрөгөөс дээш ажилд худалдан авалт хийгдээгүй тул СЯ-аар хянагдаагүй болно

- ЭМЯ ХАА-ны цахим хуудсанд мэдээлэх шаардлагатай 60 урилга нийтэлж, түүний зөвхөн 22 хувь буюу 13 тендерийн үр дүнг нийтэлсэн нь хуулийн 21.4, Засгийн газрын 2007 оны 42 дугаар тогтоол, Сангийн сайдын 2006 оны 55 дугаар тушаалаар батлагдсан журмыг зөрчсөн байна.

- **Тайлбар:** яаман дээр зарлагдсан бүх тендерийн зарыг СЯ-ны ХАА-ны цахим хуудсанд байршуулсан ба үр дүн дутуу тавигдсан нь СЯ-ны ХАА-ны цахим сүлжээ

гэмтсэнтэй холбогдон сүлжээ ажиллаагүй тул тавигдаагүй ба үр дүнг цаасан хэлбэрээр СЯ-нд өгч нэгтгэгдсэн

- ЭМЯ харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаараас давсан худалдан авалтад, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хувьд тухай бүр, барилга, байгууламжийн угсралт, засварын ажлын гүйцэтгэгчийг сонгох тендерийн хувьд үнийн дүнгээр нь багцалж ЭМЯ-ны ТНБД-ын 2008 оны 38,39, 40,41 дүгээр тушаалаар 4 удаа гүйцэтгэгчийг сонгох үнэлгээний хороо байгуулжээ. Дээрх үнэлгээний хороод ажлын бүрэлдэхүүнд орсон хүмүүсийг өөрчлөөгүй нь барилгын мэргэжлийн хүн байхгүйтэй холбоотой байна.

ЭМЯ тендерт оролцогчдын ирүүлсэн тендерийг хавтаст хэрэг болгосон ч түүнийг архивын нэгж болгоогүй, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний тусгай нөхцөл, жил бүр төсөв нэмж батлуулж буй барилга объектын шинэчилсэн төсөв, түүнийг хянаж батлахтай холбоотой материал, тендерт ялагдсан компани ЭМЯ, СЯ болон Захиргааны хэргийн шүүхэд гаргасан гомдол зэрэг материалууд хавтаст хэргээс тусдаа хадгалагдаж байна. Мөн хөрөнгө оруулалтын санхүүжилттэй холбоотой материалыг үдсэн боловч эмх цэгцгүй, хуудасны дугааргүй, товъёог байхгүй, архивын нэгж болгоогүй байна.

- **Тайлбар:** **ҮАГазрын шалгалтын мөрөөр яамны БЗА тендерийн материалыг архивын нэгж, хавтаст хэрэг болгон архивт өгөх ажлыг хийж гүйцэтгэсэн**

СЯ-наас ТЕЗ-дын 2008 оны ХАА-ны хэрэгжилтэд өгсөн үнэлгээгээр ЭМЯ 87 оноогоор “сайн” үнэлгээ авсан боловч ХАА-г хуулийн хугацаанд үнэн зөв тайлагнах явдал хангалтгүй байлаа.

- *ЭМЯ ХАА-ны тайланг хугацаанд нь СЯ-д хүргүүлсэн боловч түүнд орон нутгийн болон нэгдсэн эмнэлгүүдийн тайлан нэгтгэгдээгүй байна.*

Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журамд гэрээний үнийн дүнгээс баталгаат засварын хугацаанд гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах харилцааг тусгаагүйгээс гүйцэтгэгчтэй хийх гэрээнд үнийн дүнгээс барьцаа үлдээх талаар заадаг ч эцсийн санхүүжилтээс хэрхэн суутгаж үлдээх, түүнийг хаана ямар дансанд байршуулах, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд тэр барьцааны хөрөнгийг хэрхэн зарцуулах асуудал зохицуулагдаагүй орхигдсон байна.Тухайлбал,

ЭМЯ, “Мандал-Алтай” ХХК-ийн хооронд байгуулсан Говь-Алтай аймгийн спорт заалны засварын ажлын гэрээний тусгай нөхцөлд Барилгын тухай хуулийн 8.3-т заасны дагуу чанарын баталгаат хугацаа 365 хоног, барьцаа хөрөнгийн хэмжээ 5 хувь, урьдчилгаа төлбөр 30 хувь байхаар заасан байна. Гэвч ажил хүлээлцэхэд барьцааны 8.3 сая төгрөгийг санхүүжилтээс суутгаагүй нь баталгаат засварын хугацаанд гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалсан эвдрэл гэмтэл гарах тохиолдолд түүнд засвар хийх хөрөнгийн эх үүсвэргүй болгожээ.

- **Тайлбар:** Эрүүл мэндийн яам, “Мандал-алтай”ХХК-ны хооронд байгуулсан засварын ажил гүйцэтгэх гэрээнд “Барилгын тухай” хуулинд зааснаар баталгаат засварын хугацааг 1 жилээр тусгасан тул Мандал-алтай компаниас шалтгаалан гарсан бүх хохиролын уг компани хариуцна.

Захиалагч тал гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, тендер зарлахдаа цаашид гарах үр дагаврыг тооцоогүй зөрчил илэрлээ.

Эмнэлгийн хог хаягдлыг устгах цэгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерт “Адил-Оч”, “Норбу” ХХК-иуд шалгарч, тоног төхөөрөмжүүдээ гэрээний дагуу бэлэн болгож, хүлээлцэх баримт бичиг үйлдэж санхүүжилтээ авсан ч суурилуулах байр бэлэн болоогүйгээс нийлүүлэгчийн хашаанд хадгалагдаж байна.



Иймд "Адил-Оч" ХХК, "Норбу" ХХК-даас 235.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг яаралтай хүлээн авч, хог хаягдлын цэгт суурилуулж ашиглалтад оруулах шаардлагатай байна.

- **Тайлбар:** Нийслэл, Байгал орчны яам эмнэлгийн онц аюултай хог хаягдлыг устгах цэгийн газар олголтын асуудлыг эцэслэн шийдвэрлээгүйгээс шалтгаалан нийлүүлэгдэх тоног төхөөрөмж компани мэдэлд хадаглагдаж байгаа ба энэ оны 5 дугаар сард Нийслэлийн Улаанчулуутын хогийн цэгийг түшиглэн эмнэлгийн хог хаягдал устгах цэгийг байгуулхаар болон ажлын хэсэг ажиллан шийдвэр гаргах саналын төсөл бэлтгэн Засаг даргад оруулсан болно. Үүний дараа асуудал шийдвэрлэгдэнэ. Хотод газар шийдвэрлээгүй тохиолдолд аймгуудад байрлуулах бүрэн боломжтой юм

• *Нийслэлийн 2 дүүрэгт түргэн тусламжийн төвийн барилга барих асуудал шийдэгдээгүйгээс 30 ширхэг богино долгионы станц, түргэн тусламжийн бусад техник, тоног төхөөрөмж агуулахад ашиглалтгүй;*

• *ЭМ-ийн салбарт АНУ, Герман, Япон, Солонгос зэрэг орнуудаас тоног төхөөрөмжүүд худалдан авч суурилуулах, ашиглах явцад тухайн техникийн талаарх мэдлэг дутмагаас ХСҮТ болон Дундговь зэрэг аймагт зарим тоног төхөөрөмж ашиглалтгүй;*

Хариулт:

Эрүүл мэндийн салбарын жил бүрийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт нь бодит хэрэгцээнээс бага батлагддаг. Тиймээс хөрөнгө оруулалтаар батлагдсан төсвийг аль болох нэн шаардлагатай байгаа оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулдаг. Худалдан авах бүрт тухайн ханган нийлүүлэгчтэй гэрээ хийдэг бөгөөд гэрээнд тоног төхөөрөмж суурилуулах, ажиллуулах сургалт зарим тохиолдолд гадаад сургалтын нөхцөлийг хүртэл оруулж өгдөг. Иймээс шинээр хуваарилагдаж байгаа тоног төхөөрөмж нь зохих сургалттай байдаг. Харин зарим нэг цөөхөн тохиолдолд эмнэлэгт мэргэжлийн эмч байхгүй бөгөөд ажлаа солисон гэх шалтгаанаар уг шинэ тоног төхөөрөмж тодорхой хугацаанд ашиглагдахгүй байдаг. Гэхдээ энэ нь нийтлэг тохиолддог асуудал биш юм.

Хөрөнгө оруулалтын шинж чанартай биш үнэ багатай дагалдах хэрэгслүүдийг хөрөнгө Хөрөнгө оруулалтын шинж чанартай биш үнэ багатай дагалдах хэрэгслүүдийг оруулалтын зардлаар бэлтгэж, урсгал зардлаас хөрөнгө оруулалтын шинж чанартай хөрөнгүүд худалдан авчээ. Тухайлбал:

- *УКТЭ эмийн зардлаас 341.0 сая төгрөгөөр лабораторийн бүрэн автомат тоног төхөөрөмж;*
- *жижиг эд хогшил бэлтгэх зардлаас 99.1 сая төгрөгөөр 3 нэрийн эмнэлгийн тоног төхөөрөмж тус тус худалдан авсан байна.*

Худалдан авах ажиллагааны тайланд эмнэлгүүдэд хүлээлгэн өгснөөр тайлагнасан эмнэлгийн зарим тоног төхөөрөмж ашиглагч байгууллагад очоогүй байна. Тухайлбал, 2008 онд нийлүүлэх 7 нэрийн 711.1 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг 7 эмнэлэгт хугацаанд нь хүлээлгэн өгөөгүй байна.

Хариулт: Жил бүр худалдан авсан тоног төхөөрөмжийг ЭМС-ын тушаалын дагуу хуваарилдаг бөгөөд зарим тохиолдолд төсөвөө хэмнэх үүднээс нийтлэг хэрэглэгддэг тоног төхөөрөмжийг сургалтгүй ЭМЯ дээр шууд хүлээн авдаг. Энэ тохиолдолд хот, хөдөөгийн эмнэлгүүд ЭМЯ болон ханган нийлүүлэгчийн агуулахаас өөрсдийн биеэр ирж авдаг. Хот, хөдөөгийн эмнэлгүүд цагтаа бараагаа хүлээж авдаггүй агуулахад удаан хугацаагаар хадгалагдах тохиолдол гардаг. Энэ нь ихэвчлэн сумдын эмнэлэгт хуваарилах төхөөрөмжүүд байдаг. Гэхдээ бид аль болох мэдээлэл солилцож ямар нэг байдлаар суманд ачуулан явуулдаг. Мөн зарим нэг төхөөрөмжүүдийг ЭМЯ-ны нөөцөд авдаг. Энд дурдсан 7 нэрийн 711,1 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг 7 эмнэлэгт хугацаанд нь хүлээлгэн өгөөгүй гэсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байна. Одоогоор ЭМЯ-ны агуулахад нөөцийн болон сумдын нийт 9 нэр төрлийн

33,303,103 төгрөгний тоног төхөөрөмж байна.

ЭМЯ-ны ХСҮТ-д эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийн зарим компанитай хийсэн гэрээний үнэ өөрчлөгдсөн байна.

ХСҮТ-д эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерт шалгарсан “Меджей” компанийн тендерийн үнээс гэрээний үнийг 7.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 41.1.2-т заасан заалтыг зөрчсөн байна

ЭМ болон НД-ын байгууллагад хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн чанарт тавих хяналт сул, гэрээний биелэлтийг дүгнээгүйгээс гэрээт ажлууд хугацаандаа хийгдээгүй байна.

- *Өмнөговь аймгийн Булган сумын эмнэлгийн барилгыг 2008-2009 онд барихаар тендерт шалгарсан “Говь гурван сайхан” ХХК зөвхөн суурь тавьсан боловч түүнийг буруу тавьснаас МХГ-аас барилгын ажлыг зогсоожээ.*
- *Өвөрхангай аймгийн Спорт цогцолборын барилга угсралтын ажлын гүйцэтгэгч “Дорнын өргөө” ХХК барилгыг 2008 оны 6 сард хүлээлгэн өгөх ёстой ч санхүүжилтийн асуудлаас шалтгаалж өнөөг хүртэл дуусгаагүй байна.*

- **Тайлбар:** “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулиар 500,0 сая төгрөг хүртэлхи ажил гүйцэтгэх эрх аймаг орон нутгийн удирдлагад шилжиж байгаатай холбогдон ажлын ажлын гүйцэтгэл, чанарт тавих хяналт, санхүүжилтийн асуудлыг орон нутгийн удирдлага хариуцаж байхаар өнөөгийн тогтолцоонд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Өнөөдрийн байдлаар яам зөвхөн мэдээг авч нэгтгэх ажил хийгдэж байна. Иймд цаашид төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын тогтолцоог нарийвчлан тогтоохгүй бол энэ асуудал цаашид байнга гарах болно.

Санхүүжилт олгож буй өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна

Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.4-т “Захиалагчийн хянаж баталгаажуулсан барилгын ажлын гүйцэтгэл, барилга, их засварын ажлыг ашиглалтад хүлээн авсан тухай улсын болон орон нутгийн комиссын актыг үндэслэн санхүүжилт олгох ёстой” гэж заасныг ЭМ, НХХ-ийн салбарт жигд мөрдөн ажиллахгүй байна. Тухайлбал

- *Баянхонгор аймгийн Баацагаан сумын 10 ортой эмнэлгийн барилгыг “Өрнөх хурд” ХХК барьж 2008 оны 12 дугаар сарын 15-нд аймгийн улсын комиссын актаар хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон боловч ашиглалтад ороогүй байна.*
- *Хөвсгөл аймгийн Мөрөн сумын өрхийн эмнэлгийн барилгын ажилд 150,0 сая төгрөг батлагдаж, гадна тохижилтын ажлын гүйцэтгэлийг хуурамчаар гаргасан байхад санхүүжилтийг бүрэн олгосон.*
- *Өмнөговь аймгийн Ноён сумын эмнэлгийн засварыг дуусаагүй байхад улсын комиссын акт үйлдсэн байна.*
- *ЭМЯ-наас Архангай, Төв аймгийн Халдвартын эмнэлэг, Төв аймгийн Спорт цогцолборын гүйцэтгэгчидтэй 2008 оны 12 дугаар сард гэрээ байгуулж, барилгын материал худалдан авсан, тээврийн хөлс зарцуулснаар гүйцэтгэл гаргаж ирүүлснийг үндэслэн тухайн сард 2008 онд батлагдсан санхүүжилтийг бүрэн олгожээ.*

Дээрх байдал нь батлагдсан санхүүжилтийг ондоо багтааж зарцуулах үүднээс жилийн эцэст олон тооны барилга байгууламжийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгодог байна. Тухайлбал, ЭМЯ-наас олгож буй хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 39.9 хувийг 11-12 дугаар сард

олгосон байна.

Иймд тухайн оны батлагдсан төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Төрийн санд түр дансанд төвлөрүүлж, дараа онд олгодог байдлыг журамлах шаардлагатай байна.

- **Тайлбар:** “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулиар 500,0 сая төгрөг хүртэлхи ажил гүйцэтгэх эрх аймаг орон нутгийн удирдлагад шилжиж байгаатай холбогдон ажлын ажлын гүйцэтгэл, чанарт тавих хяналт, санхүүжилтийн асуудлыг орон нутгийн удирдлага хариуцаж байхаар өнөөгийн тогтолцоонд өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Өнөөдрийн байдлаар яам зөвхөн мэдээг авч нэгтгэх ажил хийгдэж байна. Иймд цаашид төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын тогтолцоог нарийвчлан тогтоохгүй бол энэ асуудал цаашид байнга гарах болно

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан яаралтай түргэн тусламжийн автомашин авах хөрөнгөөр ЭМЯ ажлын албанд 3 ширхэг суудлын автомашиныг 206.4 сая төгрөгөөр дур мэдэн худалдан авч хөрөнгө оруулалтын зориулалтыг өөрчилсөн байна.

- **Тайлбар:** “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай” хуулиар олгогдсон эрхийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн өмчийн хороо, сангийн сайдтай зөвшөлцсөний дагуу тушаал сайдын тушаал гарч “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу сонгон шалгаруулалт явуулан суудлын автомашин худалдан авсан болно.

Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.8-д “Зураг төсөв, техник-эдийн засгийн үндэслэл, тооцоо боловсруулахад урьдчилгаа санхүүжилт олгохгүй” гэж заасныг зөрчин зураг төсөв боловсруулах ажилд урьдчилгаа олгожээ. Тухайлбал,

- СХД-т баригдах 300 ортой төрөхийн эмнэлгийн барилгын зураг төсвийг боловсруулж буй ООО “Дарханстрой”-той гэрээ байгуулсан өдрөөс хойш 5 хоногийн дотор гэрээний үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх санхүүжилт олгожээ.
- Төв аймгийн спорт цогцолборын зураг төсөв боловсруулах гэрээг “Хөх бичээч” ХХК-тай байгуулж, урьдчилгаа 7.2 сая төгрөгийг 3 хоногт багтаан олгохоор гэрээнд заажээ.

Хөрөнгө оруулалтын нэг төсөл арга хэмжээ хэд хэдэн эх үүсвэрээс зэрэг санхүүжих тохиолдол байна.

- Төв аймагт баригдаж буй Халдварт сүрьеэгийн 30 ортой эмнэлгийн барилга угсралтын ажлыг 389.8 сая төгрөгт багтаан хийх гэрээг 2008 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр байгуулсан. Гэвч төсөвт өртөг нэмэгдэж 600.0 сая төгрөг болж байгаа гэдэг үндэслэлээр ЭМЯ-наас Дэлхийн зөн ОУБ-т нэмэлт 200.0 сая төгрөгийн санхүүжилт авах санал боловсруулан тавьсан байна.
- Архангай аймагт баригдаж буй Халдварт сүрьеэгийн 30 ортой эмнэлгийн гэрээний дүн 599.5 сая төгрөг ба үүний 449.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 150.0 сая төгрөгийг Дэлхийн зөн ОУБ-аас санхүүжүүлэх гурвалсан гэрээг 2008 оны 12 дугаар сарын 5-ны өдөр байгуулжээ.
- Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгонд зураг төсөв нь бэлэн болоогүй олимпын бэлтгэлийн төвийн барилга барих 1250.0 сая төгрөгийн гурвалсан гэрээг 2007 оны 8 дугаар сарын 1 ний өдөр БТСУХ, МҮОХ, Нийслэл өргөө ХК-ийн хооронд байгуулсан байна. Засгийн газрын 2007 оны 249 дүгээр тогтоолоор 250.0 сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс, 500.0 сая төгрөгийг 2008 оны улсын төсвөөс, үлдэх 500.0 сая төгрөгийг МҮОХороо санхүүжүүлэхээр гэрээгээр үүрэг

хүлээсэн байна.

- **Тайлбар:** “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулиар 500,0 сая төгрөг хүртэлхи ажил гүйцэтгэх эрх аймаг орон нутгийн удирдлагад шилжиж байгаатай холбогдон ажлын гүйцэтгэл, чанарт тавих хяналт, санхүүжилтийн асуудлыг орон нутгийн удирдлага хариуцаж байхаар өнөөгийн тогтолцоонд өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Өнөөдрийн байдлаар яам зөвхөн мэдээг авч нэгтгэх ажил хийгдэж байна

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж буй ажилтнуудын хоорондын ажлын уялдаа холбоо оновчтой биш байна

ЭМ-ийн сайдын 2003 оны 71 дүгээр тушаалаар ЭМЯ-ны Барилга захиалагчийн албыг байгуулж, ТӨААТҮГ статустай аж ахуйн нэгж болгожээ.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 20 дугаар зүйлд “энэ хуулиар зохицуулагдаагүй бусад харилцааг Компанийн тухай хуулиар зохицуулна” гэж заасныг дагаж мөрдөөгүйгээс тус албаны орлого зарлагын төлөвлөгөөг баталдаг, тайлан балансыг авч хэлэлцдэг газар байхгүй болжээ. Иймд тус албыг Сангийн яамны БЗА-д буюу ЭМЯ-ны Хөрөнгө оруулалтын хэлтэст нэгтгэх асуудлыг судалж шийдвэрлэх хэрэгтэй байна.

ЭМЯ-ны Төрийн сан дахь Хөрөнгө оруулалтын харилцах данснаас 2008 онд БЗА-д 301.1 сая төгрөг шилжүүлснийг 104.9 сая төгрөгийг нь орлогоор, 196.2 сая төгрөгийг нь өглөгөөр бүртгэжээ. 2008 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан өглөгийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.4-д “...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэснийг зөрчсөн байна.

ЭМЯ-ны санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан ажилтнууд аудитад шаардлагатай хөрөнгө оруулалтын судалгааг хугацаанд нь үнэн зөв гаргаж ирүүлээгүйгээс нэгдсэн эмнэлгүүд болон аймгуудын судалгааг аудиторуд аудитын явцад нэгтгэлээ.

Эрүүл мэндийн салбар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1-д “Аж ахуйн нэгж ,байгууллага нь хөрөнгөө ... Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын дагуу үнэлж, дансанд тусгана” гэж заасныг зөрчиж, ашиглалтад хүлээн авсан барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмжийг санхүүгийн бүртгэл, тайлан тэнцэлд тусгаагүй байна.Тухайлбал,

- ЭМЯ 2008 оны эцэст “БСБ Сервис” ХХК-иас хүлээн авсан 8.2 сая төгрөгийн үнэ бүхий 12 ширхэг агааржуулагчийн зориулалтыг өөрчлөн яамны өрөөнүүдэд суурилуулсан боловч нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байв..
- Өмнөговь аймгийн нэгдсэн эмнэлэг ЭМЯ-наас хуваарийн дагуу олгосон эмнэлгийн тоног төхөөрөмжийг 57.1 сая төгрөгийн илүү үнээр орлого болгосон, 1.6 сая төгрөгийн хүчил төрөгч өтгөрүүлэгчийг бүртгэлд тусгаагүй байна.

Тайлбар: Эрүүл мэндийн сайдын 2009 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 22 тоот хөрөнгө үндсэн хөрөнгөд бүртгэх тушаал гарсаны дагуу яамны эхний хагас жилийн тайлан балансанд тусгах болсон

Зөвлөмж:

- Үндэсний хөгжлийн цогц бодлого, эрүүл мэндийн талаар төрөөс барих бодлоготой уялдуулан хөрөнгө оруулалтын дунд хугацааны төлөвлөгөө батлуулж мөрдөх.
- Тендерийн баримт бичгийг бүрдүүлж архивын нэгж болгон хадгалах талаар тодорхой

арга хэмжээ зохион байгуулах.

Байгууллагын санал:



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2009 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5 "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Эрүүл мэнд, Ниймгийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт улс, орон нутгийн төсөв, МУХС, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2008 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр.Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т заасны дагуу аудитын явцад илэрсэн төлбөрийн жагсаалтыг хавсралт №1-ээр, зөрчлийн жагсаалтыг хавсралт №2-оор баталсугай.

Гурав.Аудитын тайланг Сангийн сайд С.Баярцогт, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди нарт хүргүүлсүгэй.

Дөрөв.Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2009 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

Тав.Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт үүрэг болгосугай.



Ч.Раднаа

Ч.РАДНАА

070091
tushaal